

ШИРЭЭН ДЭЭР БИЧСЭН “ТЕКСТИЙН” ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Ж.Отгонбаяр, Т.Нэмэхжаргал

Монгол улсын боловсролын их сургууль, Нийгмийн ухааны сургууль

Түлхүүр үгс : Хүний мөн чанар, Ухамсаргүй, Ид, Эго, Супер-Эго, эротик шинж, либидо

Бидний энэхүү эргэцүүллийн зорилго нь энд өгүүлэх нөхцөл байдлаас гарах арга зам, гарцыг хатуу зааж өгөхөд бус, харин уг асуудлыг Зигмунд Фрейдийн санал болгосон онолын үүднээс авч үзэж, тайлбарлаж болох юм гэсэн санааг хөндөхөд оршиж байгаа болно.

Философи сэтгэлгээний түүхэн хөгжлийг нэгэн бүхэл болгон авч үзвэл түүний гол цөм нь хүний мөн чанар, оршихуйн утга учрын тухай асуудал байдаг билээ. Нэг ёсондоо энэ бол үе үеийн суут сэтгэгчдийн оюуны бяд хүчийг сорьж шалгасан мөнхийн шинэ асуудал юм.

З.Фрейд “Мөсөн уул”-аар дамжин авирсаар дээрх асуудлын нууцад нэвтэрч нэгэн өвөрмөц хариуг олсон байдаг. Тэрээр хүний мөн чанар хийгээд соёл, иргэншлийн үйл явцыг сэтгэц задаргааны онолоор тайлбарласан явдал үнэхээрийн содон үзэгдэл мөн байсан бөгөөд энэ нь өрнийн олон урсгал чиглэлд тусгалаа олж үргэлжлэн хөгжихдөө улам философи агуулгатай болж байна.

Психоаналитик сургаалын нэгэн гол ойлголт нь хүний далд ухамсар, ухамсаргүйн тухай юм. Энэхүү ойлголтыг Өрнийн философи сэтгэлгээнд З.Фрейдээс өмнө Г.Лейбниц, И.Кант, В.Гегель, С.Кьеркегор, Э.фон Гартман, А.Шопенгауэр, Ф.Ницше нар тодорхойлох оролдлого хийсэн байдаг. Тэдгээр сэтгэгч уг ойлголтыг ухамсрын онтологи болон гносеологитой нь холбон авч үзсэн бол З.Фрейд ухамсрын тухай ойлголтыг орвонгоор нь эргүүлж, философид шинэ хэмжүүр оруулж ирсэн юм. Энэ нь Эго, Супер-Эго, Ид гэсэн гуравч бүтэцтэй холбоотой. Тийм ч учраас ухамсаргүйд илүү ойртож, хамгийн бат нот тайлбар хийсэн нь З.Фрейд байлаа. Ингэснээрээ хүнийг дотоод далд ертөнцөд нь байх иррациональ хүсэл тэмүүлэл бүхий ухамсаргүйн цул эрч хүч байдлаар тайлбарлахад хүрсэн байна.

3.Фрейд Ид хэмээх цул хүчний шид чанарыг дараах байдлаар авч үзжээ. Тухайлбал, тэрээр нэгд, хүүхэд бага насанд (инфантиль сексуаль байдал) зонхилон бүрэлддэг, *хоёрт*, ухамсрын хүрээнээс шахагдаж түрэгдсэн хүсэл мөрөөдөл, бодол санаа байдаг, *гуравт*, нэгэнт тийм болохоор логик болон ухамсарт үл өгөгддөг, *дөрөвт*, нэгэнт эдгээрт үл өгөгдөх тул рациональ байдлаар тодорхойлох аргагүй, тийм гэхийн тэмдэггүй хүч байдаг, *тавд*, ухамсар, хүсэл зоригоос үл хамаарах учир нэн бодитой, объектив шинжтэй байдаг, *зургаад*, нэгэнт объектив хүч мөн болохоор хүний язгуур чанар, авир үйлдлийг тодорхойлдог, цаашлаад эдипын комплекс, сублимацийн үйл явцаар дамжин нийгэм-түүхийн буюу соёл, иргэншлийн үзэгдлийг тайлбарлах боломж олгодог.

Өрнийн философи сэтгэлгээний түүхэнд хүнийг

-“Улс төрийн амьтан”

-“Бүх юмсын хэмжүүр”

-“Хөдөлмөрийн багаж бүтээгч амьтан”

-“Оюун ухаант амьтан”

-“Төгс бус, нүгэлт амьтан”

-“Бурханлиг адгуус”

-“Нэгэн төрлийн машин”

-“Биологийн дүрсийн дээд оргил”

-“Нийгмийн амьтан”

-“Хаягдаж гээгдсэн адгуус”

-“Символ бүтээгч амьтан” гэх зэрэг олон янзаар тодорхойлсон байдаг.

Харин 3.Фрейд хүнийг *эротик амьтан* мөн болох талаас нь авч үзжээ. Ингэж авч үзэхдээ либидо суурьтай ухамсаргүйд тэргүүлэх ач холбогдлыг оноодог.

3.Фрейд хүний амьдралд оюун ухаан чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй учраас түүний оршихуйн сүүдэртэй тал хийгээд иррациональ эхлэлрүү хандаад байгаа юм биш гэдгийг зориуд тэмдэглэе. Үүнийг 3.Фрейдийн дараах үгнээс харж болно. “Бид хүний оршихуйн сүүдэртэй тал, муу бүхнийг онцлон тэмдэглэхийн учир бол эдгээрийн оршин байгааг үл

зөвшөөрөн үгүйсгэгчид байдаг явдал юм. Иймэрхүү үгүйсгэл нь хүний сэтгэцийн амьдралыг өчүүхэн төдий ч сайжруулахгүй, харин ч улам ойлгомжгүй болгож байна. Хэрвээ бид ёс суртахууны нэрийг барьсан өрөөсгөл үгүйсгэлээс татгалзаж чадвал хүний язгуур мөн чанар дахь буян хийгээд нүглийн харилцааны хэлбэрийг тодорхойлж болох юм" (Фрейд З. Лекции по введению в психоанализ. М., 1923, т.1, с.152-153). Тэрээр өөр нэгэн бүтээлдээ "Оюун ухааны давамгайлах утга холбогдол алс ирээдүйд байх ба харин тэр нь төгсгөлгүй алс ирээдүй биш юм" (Фрейд З. Будущее одной иллюзии. —В кн: Сумерки богов. М., 1990. стр.140) хэмээн онцолсон байдаг.

Соёл иргэншил, хөгжил дэвшлийн дарамтанд орж өөрийгөө өнгөлөн далдлагч хүний түрэгдэж шахагдсан хүсэл эрмэлзлэл, бодол санаа нь элдэв янзын андуурал, эндүүрэл, хэл хальтарч ам алдахаас эхлээд бичиг үсэг, хэл ярианы санамсаргүй үйлдэл, зүүдний ажил, архи дарс болж ухаан санаа хөөрөх, мансуурах, сэтгэл догдолж баярлах, гуних үйл гэх мэт үй олон төрхөөр дамжин илэрч байдаг. Ийн илрэх бүрдээ эзэн субъектээ илчилж нээж байдаг.

Асуудалд энэ өнцгөөс хандаж үзвэл эрт цагийн хадны сүг зураг ч тэр, эдүгээ цагийн "ширээний бичээс" ч тэр, ялгаагүй, хүний Идийн илрэл юм. Хад чулууны сүг зураг бол эртний хүмүүс өөрсдийгөө шингээж үлдээсэн нэгэн төрлийн символчлол мөн гэж үздэгийн адил эдүгээ цагийн оюутны ширээн дээр бичигдсэн "текстийг" "зураач" залуусынх нь сэтгэл санааны илэрхийлэл, З.Фрейдийн нэрлэснээр, Ид нь өрж барж, байж ядан, "сад тавьсны" ул мөр мөн хэмээн үзэж болмоор санагдана. Уран зургийн галерей мэт эдгээр бичвэрийг текст болох тухайд нь герменевтик хэрэгсэл, тайлал зүй, интерпретацийн аргыг ашиглан далд утгыг нээн ойлгож болох биз ээ.

Бид энд уг текстийг бичих нь зөв үү, буруу юу, сайхан уу, муухай юу гэх мэт хүмүүжил, ёс суртахууны асуудлыг хөндөж хэн нэгнийг зэмлэж буруушаахыг ярианы сэдэв болгоогүй гэдгээ тэмдэглэе. Харин уг галерейг текст болох талаас нь биш, мөнөөх Идийн илрэл болох утгаар нь санаагаа товч хэлхэж тэрлэж байна.

Ширээн дээр бичдэг, дүрсэлдэг, сийлдэг, шивээслэдэг, урладаг, шүлэглэдэг, "ярилцаа" хийдэг шалтаг хийгээд нөхцөл олон янз байгаа нь

мэдээж. Тэр бүгдийг гүйцэд бүртгэнэ гэвэл чухамдаа Идийн задаргааг хийж, бүхэл бүтэн зураглал гаргана гэсэн үг бөгөөд тийм бололцоо угаасаа байхгүй билээ. Тийм ч учраас түүнийг иррациональ зүйл гэж үздэг

Өөрөөр хэлбэл, мөнөөх текстийг яагаад бичдэг вэ? гэсэн каузаль /учир шалтгааны/ асуултыг тавих нь утгагүй. Тийм шалтгаан нь Ид өөрөө юм. Харин уг шалтгааны "ажил" ширээн дээр хэрхэн хийгдэж байгаа хэлбэр хийгээд нөхцлийг тоймлон, болзмол байдлаар авч үзэж болох юм. Тэгвэл энэ текстэнд юу байна вэ, харцгаая /Зураг 1/.

- | | |
|---|--|
| 1. Хүсэл мөрөөдөл, сэтгэл хөдлөлийн илэрхийлэл | 12. Хэн нэгэнд дамжуулах гэсэн мэдээ, мэдээлэл |
| 2. Хэн нэгэнд дургүйцсэний илэрхийлэл | 13. Хайр сэтгэлээ илчилмээр санагдсан үе |
| 3. Цаг нөхцөөж суусны илрэл | 14. Дотоод бухимдлаа тайлж, тайвшрах агшин |
| 4. Хичээл сонирхолгүй байсны гэрч | 15. Зурах бичих хүслийн илэрхийлэл |
| 5. Сонсогч өөрөө ойлгох чадваргүй байсны нотолгоо | 16. Ухамсаргүй үйлдэл өрнөж байгаагийн илэрхийлэл |
| 6. Ядарч залхуурсан байдал | 17. Бусдыг завгүй байхад өөрөө өөртэйгөө хийсэн "ярилцлага" |
| 7. Багш болон бусдын шаардлагад дургүйцсэний илэрхийлэл | 18. Сэтгэл догдолж баярласны илэрхийлэл. |
| 8. Хичээлийг зөвхөн багшийн үйл хэрэг гэж үзэн хайнга хандсаны илрэл | 19. Бусдыг даган дууриах, аль эсвэл, бусадтай өөрийгөө жиших оролдлого |
| 9. Эсэргүүцэл доромжлолын илэрхийлэл | 20. Бусдаас давж гарах гэсэн мөрөөдөл |
| 10. Ноорог цаасгүй байсны гэрч баримт | 21. Нэгэнт бичиж зурсан зүйлийн үргэлжлэл |
| 11. Утсаар гаднаас ярих гэх мэт тэвдсэн үед ширээг "түр санах ой" болгосны баримт | |

22. Бусдын илэрхийлсэн санаанд өгсөн хариулт
23. Сэтгэлгээнд залхуурал бий болсны илрэл
24. Ширээний ур хээ, хэлбэр галбирыг утгажуулж буй байдал
25. Уран сэтгэмж
26. Чанга ярьж болохгүй үед "чимээгүй мэдээ" дамжих байдал
27. Үзэг харандааныхаа гарцын шалгалт
28. Ширээ бол зөвхөн ширээ биш, "харилцах" дэвтэр байдгийн илрэл
29. Хараал зүхэл хэлмээр санагдсан үе
30. Ёс суртахууны ухамсрын доройтол
31. Өөрийн ширээ биш учраас юу ч хийж болно
32. Хэн бичиж буй нь мэдэгддэггүй, иймээс юу хүссэнээ хэлж, бичиж болохын илрэл
33. Ширээнд оноосон эзэн байдаггүйн илрэл
34. Гэнэт "зурах" онгод орсон үе
35. Хобби-гийн илэрхийлэл
36. Хүний дотор байдаг заавал гадагш илрэх учиртай хүч
37. Дүрс эскиз
38. Дэвтэр, цаасны хэмнэлт
39. Нарийн логик шаардаагүй, ойр зуурын үгс, зураг
40. Анхаарлын сарнилт, сэтгэл санааны тогтворгүй үе
41. Өөрийгөө ялан дийлэлт
42. Номын санд бол даалгаврын дарамтын үе
43. Зүггүйтэх, төрхгүйтэх "хэрэгцээний" биежилт
44. Тухайн хичээлийн амьдралаас хол хөндий байгаагийн илрэл
45. Хичээлийг бичиж тэмдэглэх албадлагын эсэргүүцэл
46. Ширээн дээр бичихийг хориглох албадлагын эсэргүүцэл
47. Бичигчийн өөртөө хийж буй нээлт
48. Зугаагаа гаргалт
49. Бичхээсээ зурах нь хялбар байдгийн гэрч
50. Хичээл сургалтын талаар хатуу зорилго, итгэл үнэмшил байхгүйн илрэл
51. Зуршлын илрэл
52. Хожим шалгалтандаа хуулах материалын бэлтгэл
53. Тухайн үед хараа болон мэдрэмжид туссан содон зүйл
54. Мэдээжийн эгэл зүйлийг өвөрмөцөөр мэдэрч буй "нээлт"

55. Соёлгүй бүдүүлэг буюу
эрхэмлэх, цээрлэх ёсыг
эзэмшээгүйн илрэл
56. Нийтийн үнэт зүйлээс гажиж буй
байдал
57. Зурах болон бичих хэрэгцээгээ
урьд өмнө хангаж байгаагүйн
илрэл
58. Өөрийгөө илэрхийлэх,
хэрэгжүүлэх хэрэгцээ хангагдаж
байгаагүйн илрэл
59. Урьд өмнө байнгын хараа
хяналтанд, "болохгүйн"
дарамтанд байсны илрэл
60. Чөлөөт нөхцөл байдалд
өөрийгөө залах чадвар сулын
илрэл
61. Эрхэмлэдэг, дээдэлдэг үнэт
зүйлсээр ядмаг байгаагийн
илрэл
62. Зураг зурахад тохиромж бүхий
том талбай байгаагийн илрэл
63. Ширээн дээр зурсан зүйлс нь
зурж "болно" гэсэн зөвшөөрөл
64. Хажуугийн хүндээ тайлбарлах
хэрэгцээ
65. Дурсамж үлдээж буй байдал
66. Мэдээлэл дамжуулалт
67. Логик үйлдэл шаардлагагүй,
алогичный үйлдэл
68. Сэтгэлгээний өндөр түвшин
шаарддаггүй алогичный үйлдэл
69. Өөрийн нутаг хошуу, оршин буй
газар, анги сургуулиа дурсан
санагалзсан байдал
70. Муухай зурсан ч хамаагүй. Эмх
дэг шаардахгүй чөлөөт шинжийн
илрэл.
71. Эд хөрөнгөнд хайр гамтай
хандах өмчийн сэтгэлгээ
бүрдээгүйн илрэл
72. Чөлөөтэй сэтгэх боломж
хангагдаж байдаг агшин
73. Дотоод ганцаардлаа тайлж
гадагшлуулж буй байдал
74. Хүсэл мөрөөдлийн тодотгол
75. Зурах нь бичхээс илүү
нууцлагдмал байдгийн илрэл
76. Зураг нь бичлэгээс "хүчтэй"
мэдээлэл
77. "Байдаггүй амьтан"
78. Элдэв төрлийн эротик
зураг

Текстийн эдгээр агуулгыг багцлан бүлэглэж үзвэл цөөн зарим нь (ширээг "тэмдэглэлийн дэвтэр", эсвэл "түр санах ой" болгож буй гэх мэт) Идтэй холбоогүй нь ойлгомжтой. Харин ихэнх нь ямар нэгэн дарамт шахалт, түүнтэй холбогдон үүссэн уур уцаар, бухимдал хийгээд тэдгээрт хариу болгосон "чимээгүй" эсэргүүцэл (ёжлол, егөөдөл, хараал зүхэл, доромжлолын үгс гэх мэт) мөн гэдэг нь ажиглагдаж байна. Тэр хэмжээгээрээ З.Фрейдийн онолыг нотлох мэт санагдаж байна. Тэгэхдээ энэ нь өнөөгийн манай нийгэмд байгаа мэдээлэл-харилцаа, эдийн засаг-санхүү, улс төр-соёлын гэх мэт "өрсөлдөөний" дарамт биш.

Тодруулбал, энд бидний анхаарлыг дараах зүйл татаж байна. Нэгдүгээрт, дээрх текстийг суралцагчид чөлөөт цаг, завсарлагаанаар биш, харин ихэвчлэн хичээл орж байх цаг дор урлаж байна. Өөрөөр хэлбэл, суралцагчдад урам зориг өгч, итгэл үнэмшил нь болж, онгод жигүүрийг нь хөглөх учиртай хичээл сургалт маань дарамтын агуулгатай болоод байна гэсэн үг. Яагаад гэвэл, дээрх текстүүд тухайн хичээл нь агуулгынхаа хүмүүнлиг талыг гэсэн "тал" хичээл байсныг бидэнд сэм "ховлож" байна. Хоёрдугаарт, текстийн зонхилох хэсгийг зураг, мөн уянга найраг, дүрслэмж, эсвэл хэв ерийн үгс эзэлж буй нь логик сэтгэлгээтэй холбогдсон асуудал байгааг хэлж өгч байна. Тэдгээр нь "ядаргаанд орсон, сульдаатай логик сэтгэлгээг" буюу тархины тал бөмблөгийг амрааж байж ч мэдэх юм.

Юутай ч атугай дарамт, бухимдлын Идүүд манай ширээнүүд дээр "тааламжгүй" хувилбараараа цацарчээ.

Энэ нь ямар учир нигууртай болох тухай З.Фрейдээс асууя.

- Ид бол шидийн зүйл мөн тул бие хүн рүү нь өнгийгөөд хар гэжээ.

Тэгэхээр, хичээл, сургалт бол суралцагчийн бие хүн рүү нь хандсан амьд, асуудаллаг эргэцүүлэл, судалгаа нээлт мөн гэсэн зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ бол философидолтонд тулгуурласан боловсрол сургалтын шинэ, рефлексив загварын үндсэн зарчмуудын нэг нь юм.

В данной статье авторы подчёркивают, что в отличие от других философов Зигмунд Фрейд истолковал человека как эротического существа, проникая в глубину психической структуры личности.

Далее, они рассматривают "тексты", написанные студентами на партах, как одно из проявлений их бессознательных психических явлений, что могут быть объяснены психоаналитической теорией.

Вопрос заключается в том, что занятия являются тем местом, где "неприятным" образом реализуются эти явления. Считают, что, может быть, выход найдется на стороне рефлексивной модели образования.